

ний өдрийн хуралдаанаар Хас чандмань ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон. Харин 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар Монгол тэрбумтан ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг сэргээхээр шийдвэрлэсэн байна.

Нийт ХЗХ-дын 94.3 хувь буюу 149 ХЗХ 2012 оны нэгдүгээр улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан ирүүлсэн, харин 5.7 хувь буюу 9 нь тайлан мэдээг ямар нэг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй байна.

2012 оны нэгдүгээр улирлын байдлаар санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан мэдээгээ ирүүлээгүй 9 ХЗХ-ны нэгтгэлд хамруулсан үеийн буюу хамгийн сүүлд Хороонд ирүүлсэн санхүүгийн тайланг хугацааны хувьд авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

| д/д | Тайлангийн хугацаа | ХЗХ-ны тоо | ХЗХ-дын нэрс |
|------|--------------------|------------|--|
| 1 | 2010-II улирлаар | 1 | Солжир хөгжил |
| 2 | 2011-II улирлаар | 2 | Өгөөмөр хас, Батбаяр ар |
| 3 | 2011-III улирлаар | 1 | ТДМ |
| 4 | 2011-IV улирлаар | 5 | Нугын дэвшил, Хас чандмань, Бид тус, Хас баяжих, Халх хөгжил |
| Нийт | | 9 | |

Тайлбар: Ирүүлбэл зохих тайлан мэдээг ирүүлээгүй Хас чандмань ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2012 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн Хорооны хуралдаанаар хүчингүй болгохоор шийдвэрлэсэн байна.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2.1 Ерөнхий статистик үзүүлэлтүүд

/мянган төгрөг/

| д/д | Үндсэн үзүүлэлтүүд | 2011 оны I улирал | 2012 оны I улирал |
|-----|--|-------------------|-------------------|
| 1 | ХЗХ-дын тоо | 178 | 158 |
| 2 | Гишүүдийн тоо | 26,202 | 26,151 |
| 3 | Нийт актив | 50,697,885.9 | 67,140,841.1 |
| | Банкны салбарт эзлэх хувь | 0.8% | 0.7% |
| 4 | Нийт зээлийн өрийн үлдэгдэл | 35,860,090.0 | 53,540,939.7 |
| | Банкны салбарт эзлэх хувь | 1.0% | 1.0% |
| 5 | Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл | 2,996,415.7 | 2,386,240.2 |
| | Банкны салбарт эзлэх хувь | 0.8% | 0.8% |
| 6 | Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл | 36,420,912.6 | 48,401,800.3 |
| | Банкны салбарт эзлэх хувь | 1.2% | 1.3% |
| 7 | Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл | 7,660,162.0 | 8,554,506.7 |
| | Банкны салбарт эзлэх хувь | 3.1% | 3.2% |
| 8 | Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл | 3,681,577.4 | 4,839,850.4 |
| 9 | Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн | 455,719.7 | 1,485,147.2 |
| 10 | Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн | 176,753.8 | 318,767.2 |
| 11 | Нийт орлого | 3,345,132.0 | 4,020,282.0 |
| 12 | Нийт зардал | 3,162,120.1 | 3,490,805.1 |
| 13 | Тухайн үеийн ашиг, алдагдал | 183,011.9 | 529,476.9 |
| 14 | Активын өгөөж /ROA/ | 16.9% | 8.2% |

Тайлант улиралд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 4 ХЗХ 1,008,283.8 мянган төгрөгийн, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж 24 ХЗХ 476,863.4 мянган төгрөгийн, нийт 28 ХЗХ-ны Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн үлдэгдэл 1,485,147.2 мянган төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 1,029,427.5 мянган төгрөгөөр буюу 3.2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үүний дотор Хасбанктай франчайзын гэрээтэй 24 ХЗХ ХасБанкнаас богино хугацаат

зээлийн эх үүсвэр татсан байна. Энэ нь өртөг хямд, авах ба төлөгдөх хугацаа нь тодорхой зээлийн эх үүсвэрийг ХЗХ-д үйл ажиллагаандаа ашиглах, орлого зардлыг төлөвлөх, мөн гишүүдийн мөнгөн хадгаламжаас илүү ач холбогдолтой гэж үзэж байгаагаас Банк, ББСБ-аас богино ба урт хугацаат зээлийг авах сонирхол түлхүү байгаатай холбоотой гэж үзэж байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 158 ХЗХ-доос 69 ХЗХ Улаанбаатар хотод, 89 ХЗХ орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна. 2012 оны нэгдүгээр улирлын байдлаар 158 ХЗХ-дын орон нутгийн байршлыг үзүүлбэл:



2.2 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

/мянган төгрөг/

| д/д | Үндсэн үзүүлэлтүүд | 2011 оны I улирал | 2012 оны I улирал |
|-----|---|-------------------|-------------------|
| 1 | УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо | 74 | 69 |
| 2 | Гишүүдийн тоо | 11,401 | 11,552 |
| | <i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i> | 43.5% | 44.2% |
| 3 | Нийт актив | 43,643,677.4 | 58,792,108.1 |
| | <i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i> | 86.1% | 87.6% |
| 4 | Нийт зээлийн өрийн үлдэгдэл | 30,479,307.4 | 46,792,210.2 |
| | <i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 85.0% | 87.4% |
| 5 | Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл | 2,435,097.7 | 1,901,424.0 |
| | <i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 81.3% | 79.7% |
| 6 | Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл | 33,065,399.4 | 44,481,379.0 |
| | <i>ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 90.8% | 91.9% |
| 7 | Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө | 5,337,285.4 | 5,914,506.8 |
| | <i>ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 69.7% | 69.1% |
| 8 | Нийт хоршоологчдын өмчийн дүн | 3,159,312.3 | 4,109,186.6 |
| | <i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i> | 85.8% | 84.9% |
| 9 | Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн | 54,600.0 | 1,008,283.8 |
| 10 | Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн | 8,986.3 | 72,219.8 |
| 11 | Нийт орлого | 2,571,669.1 | 3,328,418.3 |
| 12 | Нийт зардал | 2,580,794.4 | 3,001,715.4 |
| 13 | Тухайн үеийн ашиг, алдагдал | -9,125.3 | 326,702.9 |

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 69 ХЗХ нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын 43.7 хувийг, тэдгээрийн актив 58,792,108.1 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын активын 87.6 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 69 ХЗХ нь 3,328,418.3 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт ХЗХ-дын орлогын 82.8 хувийг, харин 3,001,715.4 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт ХЗХ-дын зардлын 86.0 хувийг тус тус эзэлж байна.

2.3 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

| д/д | Үндсэн үзүүлэлтүүд | 2011 оны I улирал | 2012 оны I улирал |
|-----|---|-------------------|-------------------|
| 1 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо | 104 | 89 |
| 2 | Гишүүдийн тоо <i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i> | 14,801 | 14,599 |
| 3 | Нийт актив <i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i> | 7,054,208.6 | 8,348,733.0 |
| 4 | Нийт зээлийн өрийн үлдэгдэл <i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 5,380,782.6 | 6,748,729.4 |
| 5 | Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл <i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 561,318.0 | 484,816.2 |
| 6 | Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл <i>ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 3,355,513.2 | 3,920,421.3 |
| 7 | Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө <i>ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 2,322,876.6 | 2,639,999.9 |
| 8 | Нийт хоршоологчдын өмчийн дүн <i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i> | 522,265.1 | 730,663.7 |
| 9 | Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн | 401,119.7 | 476,863.4 |
| 10 | Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн | 167,767.6 | 246,547.4 |
| 11 | Нийт орлого | 773,462.9 | 691,863.7 |
| 12 | Нийт зардал | 581,325.7 | 489,089.8 |
| 13 | Тухайн үеийн ашиг | 192,137.2 | 202,773.9 |

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 89 ХЗХ нь нийт ХЗХ-дын 56.3 хувь ба тэдгээрийн актив 8,348,733.0 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын активын 12.4 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 89 ХЗХ нь 691,863.7 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт ХЗХ-дын орлогын 17.2 хувийг, харин 489,089.8 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт ХЗХ-дын зардлын 14.0 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын гишүүдийн тоог графикаар үзүүлбэл:



2.4 Хасбанкны франчайзын гэрээтэй ажиллаж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

/мянган төгрөг/

| д/д | Үндсэн үзүүлэлтүүд | 2011 оны I улирал | 2012 оны I улирал |
|-----|---|-------------------|-------------------|
| 1 | Хас банктай франчайзийн үйлчилгээний гэрээтэй ХЗХ-дын тоо | 64 | 52 |
| 2 | Гишүүдийн тоо | 9,834 | 9,503 |
| | <i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i> | 37.5% | 36.3% |
| 3 | Нийт актив /мян.төг/ | 3,586,929.6 | 4,211,111.5 |
| | <i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i> | 7.1% | 6.3% |
| 4 | Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/ | 2,832,683.5 | 3,368,331.9 |
| | <i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 7.9% | 6.3% |
| 5 | Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/ | 85,005.5 | 55,313.7 |
| | <i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 2.8% | 2.3% |
| 6 | Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/ | 1,109,745.9 | 1,347,338.0 |
| | <i>ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 3.0% | 2.8% |
| 7 | Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/ | 1,433,142.1 | 1,630,204.9 |
| | <i>ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i> | 18.7% | 19.1% |
| 8 | Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/ | 382,839.8 | 469,416.2 |
| | <i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i> | 10.4% | 9.7% |
| 9 | Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/ | 401,119.7 | 476,863.4 |
| 10 | Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/ | 167,767.6 | 159,599.8 |
| 11 | Нийт орлого /мян.төг/ | 525,935.8 | 378,707.2 |
| 12 | Нийт зардал /мян.төг/ | 351,446.4 | 252,566.4 |
| 13 | Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/ | 174,489.3 | 126,140.8 |

Тайлан нэгтгэх хугацаанд Хасбанктай франчайзын гэрээтэй 52 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Тайлант улиралд Тонхил хөгжил, Говийн цог зэрэг франчайзын гэрээ бүхий 2 ХЗХ-г үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадаагүй, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлээгүй үндэслэлээр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Тайлант улиралд Үүрэй толон ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны 2012 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар 3 жилийн хугацаатайгаар сунгасан байна.

ГУРАВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Активын чанар

ХЗХ-дын тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөг/


| ҮЗҮҮЛЭЛТ | 2011.03.31 | | 2012.03.31 | | Өөрчлөлт | |
|-------------------------------|---------------------|--------------|---------------------|--------------|---------------------|--------------|
| | дүн | хувь | дүн | хувь | дүн | хувь |
| 1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 49,404,382.5 | 97.4% | 65,808,876.7 | 98.0% | 16,404,494.2 | 33.2% |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | 12,352,129.5 | 24.4% | 10,905,667.4 | 16.2% | (1,446,462.1) | -11.7% |
| Касс дахь бэлэн мөнгө | 1,654,788.6 | 3.3% | 2,135,730.1 | 3.2% | 480,941.5 | 29.1% |
| Банкинд байршуулсан харилцах | 6,802,299.7 | 13.4% | 6,396,250.3 | 9.5% | (406,049.4) | -6.0% |
| Банкинд байршуулсан хадгаламж | 3,895,041.2 | 7.7% | 2,373,687.0 | 3.5% | (1,521,354.2) | -39.1% |
| ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР) | 33,381,463.5 | 65.8% | 51,545,788.1 | 76.8% | 18,164,324.6 | 54.4% |
| Нийт зээл | 35,860,090.0 | 70.7% | 53,540,939.7 | 79.7% | 17,680,849.6 | 49.3% |
| Хэвийн зээл | 31,524,179.3 | 62.2% | 50,077,633.7 | 74.6% | 18,553,454.4 | 58.9% |
| Хугацаа хэтэрсэн зээл | 1,339,495.0 | 2.6% | 1,077,065.8 | 1.6% | (262,429.2) | -19.6% |

| | | | | | | |
|---|---------------------|---------------|---------------------|---------------|---------------------|---------------|
| Чанаргүй зээл | 2,996,415.7 | 5.9% | 2,386,240.2 | 3.6% | (610,175.5) | -20.4% |
| Хэвийн бус | 377,022.0 | 0.7% | 417,490.9 | 0.6% | 40,468.9 | 10.7% |
| Эргэлзээтэй зээл | 595,146.7 | 1.2% | 276,729.3 | 0.4% | (318,417.4) | -53.5% |
| Муу зээл | 2,024,247.1 | 4.0% | 1,692,020.0 | 2.5% | (332,227.0) | -16.4% |
| (Зээлийн эрсдэлийн сан) | 2,478,626.6 | 4.9% | 1,995,151.6 | 3.0% | (483,475.0) | -19.5% |
| АВЛАГА (ЦЭВРЭЭР) | 2,919,772.3 | 5.8% | 2,700,032.3 | 4.0% | (219,739.9) | -7.5% |
| Байгууллага, хүмүүсээс авах авлага | 325,414.0 | 0.6% | 433,594.55 | 0.6% | 108,180.5 | 33.2% |
| Байгууллага, хүмүүсээс авах авлагын эрс/сан | 48,328.9 | 0.1% | 31,165.77 | 0.0% | (17,163.1) | -35.5% |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 2,642,687.1 | 5.2% | 2,297,603.55 | 3.4% | (345,083.6) | -13.1% |
| БУСАД ХӨРӨНГӨ | 203,792.8 | 0.4% | 183,233.7 | 0.3% | (20,559.1) | -10.1% |
| Материал үнэ бүхий зүйл | 126,109.6 | 0.2% | 147,439.7 | 0.2% | 21,330.1 | 16.9% |
| Урьдчилж төлсөн зардал, тооцоо | 22,897.1 | 0.0% | 27,345.2 | 0.0% | 4,448.1 | 19.4% |
| Бусад актив | 54,786.1 | 0.1% | 8,448.8 | 0.0% | (46,337.3) | -84.6% |
| ӨБУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР) | 547,224.4 | 1.1% | 474,155.2 | 0.7% | (73,069.3) | -13.4% |
| Өмчлөх бусад хөрөнгө | 612,628.3 | 1.2% | 490,201.1 | 0.7% | (122,427.2) | -20.0% |
| Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн сан | 65,403.9 | 0.1% | 16,046.0 | 0.0% | (49,357.9) | -75.5% |
| 2.ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | 1,293,503.5 | 2.6% | 1,331,964.4 | 2.0% | 38,460.9 | 3.0% |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР) | 1,187,152.8 | 2.3% | 1,283,655.7 | 1.9% | 96,503.0 | 8.1% |
| Үндсэн хөрөнгө | 1,624,829.2 | 3.2% | 1,735,184.0 | 2.6% | 110,354.8 | 6.8% |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 437,676.5 | 0.9% | 451,528.3 | 0.7% | 13,851.8 | 3.2% |
| БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | 106,350.7 | 0.2% | 48,308.6 | 0.1% | (58,042.1) | -54.6% |
| Биет бус хөрөнгө | 21,394.0 | 0.0% | 34,031.2 | 0.1% | 12,637.2 | 59.1% |
| Бусад | 84,956.7 | 0.2% | 14,277.4 | 0.0% | (70,679.2) | -83.2% |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2) | 50,697,885.9 | 100.0% | 67,140,841.1 | 100.0% | 16,442,955.1 | 32.4% |

Активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16,442,955.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд эргэлтийн хөрөнгө тэр дундаа нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17,680,849.6 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн.

Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 610,175.5 мянган төгрөгөөр, зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээ 483,475.0 мянган төгрөгөөр тус тус буурсан нь зээлийн багцын чанар сайжирсантай холбоотой байна.

Салбарын хэмжээгээр нийт активын өсөлтийг графикаар харуулбал:



Активын төвлөрлийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

| д/д | Активын хэмжээ | ХЗХ-дын тоо | Нийт актив | Нийт активт эзлэх хувь |
|-----|--|-------------|--------------|------------------------|
| 1 | 10,000,000.0 мянган төгрөгөөс дээш | 1 | 31,473,100.6 | 46.9% |
| 2 | 1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг | 7 | 19,268,123.7 | 28.7% |

| | | | | |
|---|-------------------------------------|-----|--------------|--------|
| 3 | 500,000.0-1,000,000.0 мянган төгрөг | 8 | 5,130,041.6 | 7.6% |
| 4 | 100,000.0-500,000.0 мянган төгрөг | 38 | 7,829,993.1 | 11.7% |
| 5 | 50,000.0-100,000.0 мянган төгрөг | 25 | 1,793,329.0 | 2.7% |
| 6 | 10,000.0-50,000.0 мянган төгрөг | 59 | 1,512,327.1 | 2.3% |
| 7 | 5,000.0-10,000.0 мянган төгрөг | 16 | 117,705.5 | 0.2% |
| 8 | 5,000.0 мянган төгрөг хүртэл | 4 | 16,220.5 | 0.0% |
| | Нийт дүн | 158 | 67,140,841.1 | 100.0% |

ХЗХ-ны активын төвлөрлийг ангилахад томоохон буюу активын хэмжээ хамгийн ихтэй 10 ХЗХ-ны нийт актив нь 52,389,449.9 мянган төгрөг байгаа нь 158 ХЗХ-дын нийт активын 78.0 хувийг эзэлж байна.

3.2 Зээлийн багцын чанар

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:
/мянган төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2011.03.31 | хувь | 2012.03.31 | хувь | ӨӨРЧЛӨЛТ | |
|-------------------------|---------------------|-------------|---------------------|-------------|---------------------|---------------|
| ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР) | 33,381,463.5 | | 51,545,788.1 | | 18,164,324.6 | 54.4% |
| Нийт зээл | 35,860,090.0 | 100.0% | 53,540,939.7 | 100.0% | 17,680,849.6 | 49.3% |
| Хэвийн зээл | 31,524,179.3 | 87.9% | 50,077,633.7 | 93.5% | 18,553,454.4 | 58.9% |
| Хугацаа хэтэрсэн зээл | 1,339,495.0 | 3.7% | 1,077,065.8 | 2.0% | -262,429.2 | -19.6% |
| Чанаргүй зээл | 2,996,415.7 | 8.4% | 2,386,240.2 | 4.5% | -610,175.5 | -20.4% |
| <i>Хэвийн бус</i> | <i>377,022.0</i> | <i>1.1%</i> | <i>417,490.9</i> | <i>0.8%</i> | <i>40,468.9</i> | <i>10.7%</i> |
| <i>Эргэлзээтэй зээл</i> | <i>595,146.7</i> | <i>1.7%</i> | <i>276,729.3</i> | <i>0.5%</i> | <i>-318,417.4</i> | <i>-53.5%</i> |
| <i>Муу зээл</i> | <i>2,024,247.1</i> | <i>5.6%</i> | <i>1,692,020.0</i> | <i>3.2%</i> | <i>-332,227.0</i> | <i>-16.4%</i> |
| (Зээлийн эрдэлийн сан) | 2,478,626.6 | | 1,995,151.6 | | -483,475.0 | -19.5% |

Нийт цэвэр зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18,164,324.6 мянган төгрөгөөр буюу 54.4 хувиар өссөн.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 262,429.2 мянган төгрөгөөр буюу 19.6 хувиар, муу зээлийн үлдэгдэл 332,227.0 мянган төгрөгөөр, чанаргүй зээлийн үлдэгдэл 610,175.5 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ХЗХ-дын зээлийн өрийн үлдэгдлийг интервалаар харуулбал дараах байдалтай байна.
/мянган төгрөг/

| д/д | Зээлийн үлдэгдэл /интервал/ | ХЗХ-дын тоо | Нийт зээлийн үлдэгдэл | Нийт зээлийн дүнд эзлэх хувь |
|-----|--|-------------|-----------------------|------------------------------|
| 1 | 10,000,000.0 мянган төгрөгөөс дээш | 1 | 24,898,781.5 | 46.5% |
| 2 | 1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг | 6 | 14,771,148.4 | 27.6% |
| 3 | 500,000.0-1,000,000.0 мянган төгрөг | 6 | 3,910,413.1 | 7.3% |
| 4 | 100,000.0-500,000.0 мянган төгрөг | 34 | 6,711,619.1 | 12.5% |
| 5 | 50,000.0-100,000.0 мянган төгрөг | 21 | 1,529,329.0 | 2.9% |
| 6 | 10,000.0-50,000.0 мянган төгрөг | 60 | 1,566,050.5 | 2.9% |
| 7 | 5,000.0-10,000.0 мянган төгрөг | 16 | 114,136.2 | 0.2% |
| 8 | 5,000.0 мянган төгрөг хүртэл | 14 | 39,461.9 | 0.1% |
| | Нийт дүн | 158 | 53,540,939.7 | 100.0% |

Зээлийн өрийн үлдэгдлийг бүлэглэхэд ихээхэн хэмжээний буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй нийт 13 ХЗХ-ны зээлийн өрийн үлдэгдэл

43,580,343.0 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын зээлийн өрийн үлдэгдлийн 81.4 хувийг эзэлж байна.

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

| ҮЗҮҮЛЭЛТ | 2011.03.31 | | 2012.03.31 | | Өөрчлөлт | |
|--|---------------------|---------------|---------------------|---------------|---------------------|---------------|
| | Дүн | хувь | Дүн | хувь | Дүн | хувь |
| 1. ӨР ТӨЛБӨР | 39,356,146.6 | 77.6% | 53,746,484.0 | 80.1% | 14,390,337.4 | 36.6% |
| ХАДГАЛАМЖ | 36,420,912.6 | 71.8% | 48,401,800.3 | 72.1% | 11,980,887.7 | 32.9% |
| 1. Хугацаагүй | 1,752,262.4 | 3.5% | 3,296,896.3 | 4.9% | 1,544,634.0 | 88.2% |
| 2. Хугацаатай | 34,668,650.2 | 68.4% | 45,104,903.9 | 67.2% | 10,436,253.7 | 30.1% |
| БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ | 455,719.7 | 0.9% | 1,485,147.2 | 2.2% | 1,029,427.5 | 225.9% |
| 3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл | 355,693.7 | 0.7% | 1,485,147.2 | 2.2% | 1,129,453.5 | 317.5% |
| 4. Богино хугацаат төслийн санхүүжилт | 100,026.0 | 0.2% | - | 0.0% | -100,026.0 | (1.0) |
| БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,302,760.5 | 4.5% | 3,540,769.3 | 5.3% | 1,238,008.9 | 53.8% |
| 5. Татварын төлөх өглөг | 81,417.6 | 0.2% | 105,289.4 | 0.2% | 23,871.8 | 29.3% |
| 6. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 2,040,887.4 | 4.0% | 2,718,731.0 | 4.0% | 677,843.6 | 33.2% |
| 7. Өглөг | 109,400.1 | 0.2% | 599,391.3 | 0.9% | 489,991.2 | 447.9% |
| 8. Бусад пассив | 71,055.4 | 0.1% | 117,357.6 | 0.2% | 46,302.2 | 65.2% |
| УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 176,753.8 | 0.3% | 318,767.2 | 0.5% | 142,013.4 | 80.3% |
| 8. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл | 173,683.0 | 0.3% | 269,547.4 | 0.4% | 95,864.4 | 55.2% |
| 9. Урт хугацаат төслийн санхүүжилт | 3,070.9 | | 49,219.8 | 0.1% | 46,148.9 | |
| ӨӨРИЙН ХӨРӨНГӨ | 11,341,739.4 | 22.4% | 13,394,357.1 | 19.9% | 2,052,617.7 | 18.1% |
| ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ | 7,660,162.0 | 15.1% | 8,554,506.7 | 12.7% | 894,344.8 | 11.7% |
| 10. Хувь нийлүүлсэн хөрөнгө | 7,660,162.0 | 15.1% | 8,554,506.7 | 12.7% | 894,344.8 | 11.7% |
| ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ | 3,681,577.4 | 7.3% | 4,839,850.4 | 7.2% | 1,158,273.0 | 31.5% |
| 11. Нөөцийн сан | 1,696,878.0 | 3.3% | 2,170,190.2 | 3.2% | 473,312.3 | 27.9% |
| 12. Дахин үнэлгээний сан | 268,559.8 | 0.5% | 273,435.8 | 0.4% | 4,876.0 | 1.8% |
| 13. Нийгмийн хөгжлийн сан | 250,845.1 | 0.5% | 339,552.6 | 0.5% | 88,707.5 | 35.4% |
| 14. Бусад сангууд | 120,909.5 | 0.2% | 163,971.9 | 0.2% | 43,062.4 | 35.6% |
| 15. Хандив, тусламж | 43,257.6 | 0.1% | 41,740.4 | 0.1% | -1,517.1 | -3.5% |
| 16. Бусад өмч | 270,096.4 | 0.5% | 40,071.1 | 0.1% | -230,025.3 | -85.2% |
| 17. Тайлангийн үеийн ашиг/алдагдал | 183,011.9 | 0.4% | 529,476.9 | 0.8% | 346,465.0 | 189.3% |
| 18. Хуримтлагдсан ашиг/алдагдал | 848,019.2 | 1.7% | 1,281,411.4 | 1.9% | 433,392.2 | 51.1% |
| ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2) | 50,697,885.9 | 100.0% | 67,140,841.1 | 100.0% | 16,442,955.1 | 32.4% |

ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ буюу эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16,442,955.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд хадгаламжийн хэмжээ 11,980,887.7 мянган төгрөгөөр, урт, богино хугацааны төслийн санхүүжилт, зээлийн дүн 2,409,449.8 мянган төгрөгөөр, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 894,344.8 мянган төгрөгөөр, хоршоологчдын өмчийн дүн 1,158,273.0 мянган төгрөгөөр, өр төлбөрийн дүн 14,390,337.4 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг бүлэглэн харуулбал:


| д/д | Хадгаламжийн хэмжээ /интервалаар/ | ХЗХ-ны тоо | Хадгаламжийн дүн | Нийт хадгаламжид |
|-----|-----------------------------------|------------|------------------|------------------|
| | | | | Эзлэх хувь |

| | | | | |
|-----------------------|--|-----|--------------|--------|
| 1 | 10,000,000.0 мянган төгрөгөөс дээш | 1 | 25,109,405.7 | 51.9% |
| 2 | 1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг | 4 | 13,389,741.2 | 27.7% |
| 3 | 500,000.0-1,000,000.0 мянган төгрөг | 5 | 3,621,302.5 | 7.5% |
| 4 | 100,000.0-500,000.0 мянган төгрөг | 20 | 4,154,994.4 | 8.6% |
| 5 | 50,000.0-100,000.0 мянган төгрөг | 11 | 856,602.2 | 1.8% |
| 6 | 10,000.0-50,000.0 мянган төгрөг | 46 | 1,104,757.2 | 2.3% |
| 7 | 5,000.0-10,000.0 мянган төгрөг | 13 | 102,296.5 | 0.2% |
| 8 | 5,000.0 мянган төгрөг хүртэл | 34 | 62,700.4 | 0.1% |
| 9 | Хадгаламжгүй | 24 | | 0.0% |
| Нийт хадгаламжийн дүн | | 158 | 48,401,800.3 | 100.0% |

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад томоохон буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй нийт 10 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 42,120,449.5 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 87.0 хувийг эзэлж байна.

Хадгаламж татан төвлөрүүлээгүй нийт 24 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 15.2 хувийг эзэлж байгаа ба эдгээр нь зөвхөн өөрийн хөрөнгөөрөө үйл ажиллагаагаа явуулж байна.

Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлтийг графикаар харуулбал:



Тайлант улиралд ХЗХ-дын хувь хөрөнгө 8,554,506.7 мянган төгрөг байна. Үүнийг интервалаар харуулбал:

| д/д | Хувь хөрөнгийн хэмжээ /интервалаар/ | ХЗХ-дын тоо | Хувь хөрөнгийн дүн | Нийт хувь хөрөнгөнд эзлэх хувь |
|-------------------------------|-------------------------------------|-------------|--------------------|--------------------------------|
| 1 | 2,000,000.0 мянган төгрөгөөс дээш | 1 | 2,059,987.7 | 24.1% |
| 2 | 500,000.0-1,000,000.0 мянган төгрөг | 2 | 1,149,700.0 | 13.4% |
| 3 | 100,000.0-500,000.0 мянган төгрөг | 11 | 1,943,122.9 | 22.7% |
| 4 | 50,000.0-100,000.0 мянган төгрөг | 19 | 1,258,810.7 | 14.7% |
| 5 | 15,000.0-50,000.0 мянган төгрөг | 55 | 1,633,700.3 | 19.1% |
| 6 | 10,000.0-15,000.0 мянган төгрөг | 20 | 241,171.8 | 2.8% |
| 7 | 5,000.0-10,000.0 мянган төгрөг | 26 | 189,148.3 | 2.2% |
| 8 | 1,000.0-5,000.0 мянган төгрөг | 24 | 78,865.1 | 0.9% |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | | 158 | 8,554,506.7 | 100.0% |

ХЗХ-дын хувь хөрөнгийн өсөлт дараах байдалтай байна.



ХЗХ-дын хоршоологчдын өмч 4,839,850.4 мянган төгрөг байгааг интервалаар харуулбал:
/мянган төгрөг/

| д/д | Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/ | ХЗХ-дын тоо | Хоршоологчдын өмчийн дүн | Нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь |
|----------|--|-------------|--------------------------|-------------------------------------|
| 1 | 500,000.0-2,000,000.0 мянган төгрөг | 1 | 1,539,922.8 | 31.8% |
| 2 | 100,000.0-500,000.0 мянган төгрөг | 7 | 2,100,977.3 | 43.4% |
| 3 | 50,000.0-100,000.0 мянган төгрөг | 7 | 498,946.8 | 10.3% |
| 4 | 15,000.0-50,000.0 мянган төгрөг | 30 | 869,113.3 | 18.0% |
| 5 | 10,000.0-15,000.0 мянган төгрөг хүртэл | 12 | 142,497.4 | 2.9% |
| 6 | 1,000.0-10,000.0 мянган төгрөг | 64 | 307,899.5 | 6.4% |
| 7 | 1,000.0 мянган төгрөг | 19 | 10,204.9 | 0.2% |
| 8 | Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/ | 18 | -629,711.6 | -13.0% |
| Нийт дүн | | 158 | 4,839,850.4 | 100.0% |

ТАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

5.1 Орлогын үзүүлэлтүүд

Орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2011.03.31 | | 2012.03.31 | | Өөрчлөлт | |
|--|--------------------|--------------|--------------------|--------------|------------------|--------------|
| | Дүн | ХУВЬ | Дүн | ХУВЬ | Дүн | ХУВЬ |
| ХҮҮГИЙН ОРЛОГО | 3,082,974.7 | 92.2% | 3,655,351.0 | 90.9% | 572,376.3 | 18.6% |
| Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого | 2,935,182.3 | 87.7% | 3,499,754.1 | 87.1% | 564,571.8 | 19.2% |
| Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого | 41,963.6 | 1.3% | 54,184.5 | 1.3% | 12,220.9 | 29.1% |
| Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого | 81,278.5 | 2.4% | 91,524.0 | 2.3% | 10,245.5 | 12.6% |
| Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого | 1,276.6 | 0.0% | 516.8 | 0.0% | -759.9 | -59.5% |
| Бусад хүүгийн орлого | 23,273.7 | 0.7% | 9,371.6 | 0.2% | -13,902.0 | -59.7% |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО | 150,933.4 | 4.5% | 229,525.3 | 5.7% | 78,591.9 | 52.1% |
| Элсэлтийн хураамж | 4,478.5 | 0.1% | 2,724.6 | 0.1% | -1,754.0 | -39.2% |
| Гишүүний татвар | 13,524.7 | 0.4% | 13,520.0 | 0.3% | -4.7 | 0.0% |
| Үйлчилгээний хураамж | 41,837.0 | 1.3% | 36,944.5 | 0.9% | -4,892.5 | -11.7% |
| Үйл ажиллагааны бусад орлого | 91,093.2 | 2.7% | 176,336.3 | 4.4% | 85,243.1 | 93.6% |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО | 111,223.9 | 3.3% | 135,405.8 | 3.4% | 24,181.8 | 21.7% |
| Торгуулийн орлого | - | 0.0% | 2,242.6 | 0.1% | 2,242.6 | |
| Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого | 1,619.3 | 0.0% | 4,613.5 | 0.1% | 2,994.2 | 184.9% |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого | 44,134.6 | 1.3% | 11,015.8 | 0.3% | -33,118.7 | -75.0% |
| Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого | 19,007.7 | 0.6% | 14,679.5 | 0.4% | -4,328.2 | -22.8% |
| Бусад орлого | 45,678.0 | 1.4% | 31,253.7 | 0.8% | -14,424.2 | -31.6% |

| | | | | | | |
|-----------------------|-------------|--------|-------------|--------|-----------|---------|
| Онцгой шинжтэй орлого | 585.0 | 0.0% | 71,600.6 | 1.8% | 71,015.6 | |
| Ердийн бус орлого | 199.4 | 0.0% | - | 0.0% | -199.4 | -100.0% |
| Нийт орлогын дүн | 3,345,132.0 | 100.0% | 4,020,282.0 | 100.0% | 675,150.0 | 20.2% |

2012 оны нэгдүгээр улиралд ХЗХ-дын орлого 4,020,282.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 675,150.0 мянган төгрөгөөр буюу 20.2 хувиар өссөн нь зээлийн хүүгийн орлого 572,376.3 мянган төгрөгөөр, үйл ажиллаганы бусад орлого 78,591.9 мянган төгрөгөөр, үйл ажиллаганы бус орлого 24,181.8 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Сидан ХЗХ 5,171.9 мянган төгрөгийн, Грави ХЗХ 66,428.6 мянган төгрөгийн, нийт 71,600.6 мянган төгрөгийн онцгой шинжтэй орлогыг тайлант тусгасан байна. Үүнийг газар дээрх шалгалтаар болон зайны хяналтыг хэрэгжүүлж буй хянан шалгагч нь анхаарч, тодруулж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

5.2 Зардлын үзүүлэлтүүд

Зардал дараах бүтэцтэй байна. Үүнд:

| ҮЗҮҮЛЭЛТ | 2011.03.31 | | 2012.03.31 | | Өөрчлөлт | |
|--|--------------------|---------------|--------------------|---------------|------------------|--------------|
| | Дүн | ХУВЬ | Дүн | ХУВЬ | Дүн | ХУВЬ |
| ХҮҮГИЙН ЗАРДАЛ | 1,839,767.1 | 58.2% | 2,060,065.0 | 59.0% | 220,297.9 | 12.0% |
| Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал | 742,957.1 | 23.5% | 990,170.2 | 28.4% | 247,213.1 | 33.3% |
| Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүргэлх) | 840,860.2 | 26.6% | 993,924.0 | 28.5% | 153,063.8 | 18.2% |
| Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жил) | 132,955.9 | 4.2% | 37,617.7 | 1.1% | -95,338.3 | -71.7% |
| Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал | 121,867.6 | 3.9% | 37,292.6 | 1.1% | -84,575.1 | -69.4% |
| Бусад хүүгийн зардал | 1,126.1 | 0.0% | 1,060.5 | 0.0% | -65.6 | -5.8% |
| БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ | 435,145.9 | 13.8% | 494,218.2 | 14.2% | 59,072.3 | 13.6% |
| Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал | 405,764.4 | 12.8% | 241,941.5 | 6.9% | -163,822.9 | -40.4% |
| Авлагын болзошгүй эрсдэлийн зардал | 13,440.3 | 0.4% | 251,689.3 | 7.2% | 238,249.0 | 1772.7% |
| Өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал | 2,222.7 | 0.1% | - | 0.0% | -2,222.7 | -100.0% |
| Бусад эрсдэлийн зардал | 13,718.6 | 0.4% | 587.5 | 0.0% | -13,131.1 | -95.7% |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 761,489.7 | 24.1% | 802,414.9 | 23.0% | 40,925.1 | 5.4% |
| Боловсон хүчний зардал | 470,436.0 | 14.9% | 480,310.4 | 13.8% | 9,874.4 | 2.1% |
| Бусад зардал | 291,053.7 | 9.2% | 322,104.4 | 9.2% | 31,050.7 | 10.7% |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 125,717.4 | 4.0% | 134,107.1 | 3.8% | 8,389.7 | 6.7% |
| Торгуулийн зардал | 1,213.7 | 0.0% | 1,500.7 | 0.0% | 287.0 | 23.6% |
| Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз | 99.0 | 0.0% | 536.0 | 0.0% | 437.0 | 441.4% |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал | 69,326.6 | 2.2% | 24,673.2 | 0.7% | -44,653.3 | -64.4% |
| Үйл ажиллагааны бус бусад зардал | 4,617.1 | 0.1% | 11,629.8 | 0.3% | 7,012.7 | 151.9% |
| Ердийн бус зардал | 12.4 | 0.0% | 614.2 | 0.0% | 601.7 | 4845.0% |
| Татварын зардал | 50,448.5 | 1.6% | 95,153.2 | 2.7% | 44,704.6 | 88.6% |
| Нийт зардлын дүн | 3,162,120.1 | 100.0% | 3,490,805.1 | 100.0% | 328,685.0 | 10.4% |

Тайлант улиралд нийт зардлын хэмжээ 3,490,805.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 328,685.0 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар өссөн. Үүнд хадгаламжийн хүүгийн зардал 220,297.9 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 40,925.1 мянган төгрөгөөр, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 59,072.3 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардал 8,389.7 мянган төгрөгөөр тус тус өссөн өөрчлөлт гарсан байна.

5.3 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-д

Нийт 158 ХЗХ-дын 26 ХЗХ буюу 16.5 хувь нь 402,032.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнд:

| д/д | Алдагдлын хэмжээ /интервалаар/ | ХЗХ-дын тоо | Алдагдлын хэмжээ | Нийт алдагдалд эзлэх хувь |
|-----|--|-------------|------------------|---------------------------|
| 1 | 400,000.0 мянган төгрөгөөс дээш | 1 | 360,185.1 | 89.6% |
| 2 | 10,000.0-50,000.0 мянган төгрөг хүртэл | 1 | 12,194.1 | 3.0% |
| 3 | 1,000.0-10,000.0 мянган төгрөг хүртэл | 9 | 24,931.6 | 6.2% |
| 4 | 500.0-1,000.0 мянган төгрөг хүртэл | 2 | 1,293.6 | 0.3% |
| 5 | 500.0 мянган төгрөг хүртэл | 13 | 3,428.2 | 0.9% |
| | Нийт дүн | 26 | 402,032.5 | 100.0% |

Алдагдалтай ажиллаж байгаа ХЗХ-дын 17 буюу 65,4 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдгээрийн алдагдал 395,077.3 мянган төгрөг байгаа нь ХЗХ-дын нийт алдагдлын 98.3 хувийг эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 9 ХЗХ-ны 6,955.3 мянган төгрөгийн алдагдал нь ХЗХ-дын нийт алдагдлын 1.7 хувийг эзэлж байна. Үүний дотор Хасбанктай франчайзын гэрээтэй 6 ХЗХ-ны 4,859.7 мянган төгрөгийн алдагдал нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй алдагдалтай ажилласан ХЗХ-дын нийт алдагдлын 69.9 хувийг эзэлж байна.

Зоосон мөнгө ХЗХ 360,185.1 мянган төгрөгийн, Алтан давалгаа ХЗХ 12,194.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь ХЗХ-дын нийт алдагдлын 92.6 хувийг эзэлж байна.

5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-д

Нийт 158 ХЗХ-доос 132 ХЗХ буюу 83.5 хувь нь 931,509.5 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Үүнд:

Ашгийн хэмжээгээр ангилахад дараах байдалтай байна. Үүнд:

| д/д | Ашгийн хэмжээ /интервалаар/ | ХЗХ-дын тоо | Ашгийн хэмжээ | Нийт ашигт эзлэх хувь |
|-----|---|-------------|---------------|-----------------------|
| 1 | 350,000.0 мянган төгрөгөөс дээш | 1 | 372,556.7 | 40.0% |
| 2 | 50,000.0-100,000.0 мянган төгрөг хүртэл | 1 | 67,229.4 | 7.2% |
| 3 | 10,000.0-50,000.0 мянган төгрөг хүртэл | 12 | 281,394.5 | 30.2% |
| 4 | 5,000.0-10,000.0 мянган төгрөг хүртэл | 14 | 105,232.8 | 11.3% |
| 5 | 1,000.0-5,000 мянган төгрөг хүртэл | 31 | 75,340.7 | 8.1% |
| 6 | 1,000.0 мянган төгрөг хүртэл | 73 | 29,755.3 | 3.2% |
| | Нийт дүн | 132 | 931,509.5 | 100.0% |

Тайлант улиралд ашигтай ажилласан 52 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн нийт ашгийн хэмжээ 720,780.3 мянган төгрөг буюу ХЗХ-дын нийт ашгийн 77,5 хувийг эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 80 ХЗХ 209,729.2 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь ХЗХ-дын нийт ашгийн 22.5 хувийг, Хасбанктай франчайзын гэрээтэй 46 ХЗХ 131,000.5 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ашигтай ажилласан ХЗХ-дын нийт ашгийн 62.5 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРГАА. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ АКТИВААР БҮЛЭГЛЭВЭЛ:

Хорооноос ХЗХ-дод хийж буй газар дээрх шалгалтыг үр өгөөжтэй зохион байгуулах, чанаржуулах, нэг бүлэгт хамаарагдаж буй ХЗХ-дыг харьцуулах замаар тэдгээрийн санхүү, төлбөрийн чадварын байдалд бодит үнэлгээ өгөх зорилгоор активын хэмжээгээр нь 4 ангилж бүлэглэвэл:

| Бүлгийн дугаар | Бүлэглэсэн активын интервал | Бүлэгт багтах ХЗХ-н тоо | ХЗХ-нд эзлэх хувь | Нийт активт эзлэх хувь | Үүнээс | |
|----------------|-----------------------------|-------------------------|-------------------|------------------------|--|---|
| | | | | | УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ын тоо | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ын тоо |
| Бүлэг-1 | 50.0 сая төгрөг хүртэл | 79 | 50.0% | 2.5% | 28 | 51 |
| Бүлэг-2 | 50-500.0 сая төгрөг | 63 | 39.9% | 14.3% | 29 | 34 |
| Бүлэг-3 | 500.0-1.0 тэрбум төгрөг | 8 | 5.1% | 7.6% | 4 | 4 |
| Бүлэг-4 | 1.0 тэрбумаас дээш | 8 | 5.1% | 75.6% | 8 | 0 |
| Нийт дүн | | 158 | 100.0% | 100.0% | 69 | 89 |

ДОЛОО. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр хувьд Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдаж, 2012 оны 62 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

| | ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД | БАЙВАЛ ЗОХИХ | ТАЙЛАНГААР |
|----------|--|-----------------|------------------|
| А | АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН | | |
| 1 | АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+илүү, -дутуу) /мянган төгрөгөөр/ | 1,988,610.7 | 1,995,151.6 |
| 2 | ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ (5 хувиас хэтрэхгүй) | 5.0% | 4.5% |
| 3 | ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (30 хувиас доош) | 30.0% | 30.0% |
| Б | ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ | | |
| 4 | НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ (60-80 хүртэлх хувь) | 60%-80% | 76.8% |
| 5 | ӨБҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй) | 5.0% | 0.71% |
| 6 | ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (15 хувиас хэтрэхгүй) | 15.0% | 0.02% |
| 7 | ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (80 хүртэлх хувь) | 80.0% | 72.1% |
| 8 | БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (20 хувиас хэтрэхгүй) | 20.0% | 2.6% |
| 9 | ГИШҮҮДИЙН НИЙТ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас дээш) | 5.0% | 12.7% |
| 10 | НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас хэтрэхгүй) | 10.0% | 7.2% |
| 11 | НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ | 820,434,302.16 | 2,170,190,249.53 |
| В | ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ | | |
| 12 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН (15 хувиас хэтрэхгүй) | 15.0% | 1.2% |
| Г | ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР | | |
| 13 | ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (5 хувиас дээш) | 5.0% | 8.6% |

| Д | ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ) | | |
|----|--|--|------|
| 14 | АКТИВЫН ӨГӨӨЖ | | 1.1% |

ХЗХ-дын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр активын эрсдэлийн санг 6,540.9 мянган төгрөгөөр илүү байгуулснаас бусад шалгуур үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

2012 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт 158 ХЗХ хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Улаанбаатар хотод 69 ХЗХ, орон нутагт 89 ХЗХ үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийт ХЗХ-доос 149 буюу 94.3 хувь нь зохих журмын дагуу 2012 оны нэгдүгээр улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг ирүүлсэн, 9 буюу 5.7 хувь нь ирүүлбэл зохих тайлан мэдээг хугацаанд нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй байна.

2011 оны жилийн эцсийн байдлаар тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн 6 ХЗХ байснаас 2012 оны нэгдүгээр улирлын байдлаар Си Ди Ко, Тонхил хөгжил, Ижил хүлэг, Говийн цог зэрэг 4 ХЗХ-ны, 4 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар Хас чандмань ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон. Харин 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар Монгол тэрбумтан ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг сэргээхээр шийдвэрлэсэн ба 2012 оны нэгдүгээр улиралд Зоосон мөнгө ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн байна.

2012 оны нэгдүгээр улирлын байдлаар 158 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байгаа нь 2011 оны мөн үетэй харьцуулахад тооны хувьд 20-оор буурсан хэдий ч санхүүгийн болон үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн хувьд тодорхой хэмжээний өсөлтүүд гарч чанарын ахицтай байна. Тухайлбал:

1. Нийт актив

Нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16,442,955.1 мянган төгрөгөөр буюу 24,5 хувиар өсөж, банкны салбарын 0,7 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын хувьд дундаж активын хэмжээ 852,059.5 мянган төгрөг, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж ХЗХ-ны дундаж активын хэмжээ 93,806.0 мянган төгрөг байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-ны хувьд 262,280.1 мянган төгрөгөөр, орон нутгийн ХЗХ-ны хувьд 25,977.1 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

2. Нийт зээлийн өрийн үлдэгдэл

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн багц 17,680,849.6 мянган төгрөгөөр буюу 49,3 хувиар өсөж, банкны салбарын 1.0 хувийг эзэлж байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 262,429.2 мянган төгрөг буюу 19.6 хувиар буурсан байна. Тайлант улиралд муу зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 332,227.0 мянган төгрөгөөр, чанаргүй зээлийн хэмжээ 610,175.5 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

3. Татан төвлөрүүлсэн хадгаламж

ХЗХ-дын хадгаламжийн хэмжээ 11,980,887.7 мянган төгрөгөөр буюу 32,9 хувиар өсөж, банкны салбарын 1,3 хувийг эзэлж байна. Хадгаламжийн төрлийн хувьд авч үзвэл хугацаатай хадгаламжийн хэмжээ 10,436,253.7 мянган төгрөгөөр өссөн байна.

4. Хувь хөрөнгийн хэмжээ

Хувь хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 894,344.8 мянган төгрөгөөр өсч, банкны салбарын 3,2 хувийг эзэлж байна. Сүүлийн 6 жилийн тоон мэдээллээс харахад тайлант жилд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ хамгийн ихээр өссөн байна. Үүнийг графикаар харуулбал дараах байдалтай байна.



5. Хоршоологчдын өмч

Хоршоологчдын өмчийн хэмжээ өмнөх оны мөн үеийн байдлаас 1,158,273.0 мянган төгрөгөөр өссөн. Хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн хэмжээ өссөн нь бусдын өмнө ХЗХ-дын хүлээх үүрэг хариуцлага өндөржиж, өөрийн хөрөнгийн чадавхи дээшилсэн эерэг үзүүлэлт гэж дүгнэж байна.

6. Нийт орлого, ашиг

ХЗХ-дын үйл ажиллагаа сайжирч, өргөжиж байгаатай холбоотойгоор, нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад 675,150.0 мянган төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 328,685.0 мянган төгрөгөөр өссөн байна. 2012 оны нэгдүгээр улирлын байдлаар тайлант үеийн ашиг 529,476.9 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ХЗХ-доос 2011 оны зохицуулалтын үйлчилгээний хөлс 14,269.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээс тайлант улирлын байдлаар 13,115.9 мянган төгрөг буюу 91.2 хувийг төсөвт төвлөрүүлсэн, нэг удаа төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс тусгай зөвшөөрлийн сунгалтын хураамж болох нийт 350,0 мянган төгрөг төлөгдөхөөс 350,0 мянган төгрөг буюу 100.0 хувь төлөгдсөн байна.

Аудитын тухай хуулиар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх ХЗХ-д санхүүгийн жилийн эцсийн тайлангаа заавал баталгаажуулах үүрэгтэй. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулж байгаад хяналт тавин ажиллалаа. 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар хуулийн хэрэгжилт 71,5 хувьтай байна. Мөн 2012 оны нэгдүгээр улирлын байдлаар ирүүлсэн тайлан мэдээг хянаж нийт 125 ХЗХ-нд анхаарах болон зөвлөх зүйлийн талаар хариу бичгүүдийг хүргүүлээд байна.

2012 оны нэгдүгээр улирлын байдлаар зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 9 ХЗХ бүрэн хангаж ажилласан, 130 хоршоо 1-4 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй, 19 хоршоо 5-7 үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй зөрчил гарсан байна.

Хороонд 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар “Хадгаламж, зээлийн хоршооны тухай” бие даасан хууль 2011 оны 10 дугаар сарын 27-ны өдөр батлагдсантай холбоотойгоор хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хуульд нийцүүлэн боловсруулсан дүрэм, журмыг Бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, шийдвэрийн хамт нэр бүхий 91 ХЗХ-ноос ирүүлсэн байна.

Цаашид хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс ХЗХ-дын улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга тэмдэг болон дүрэм, журам, заавруудад хуулийн дагуу өөрчлөлт хийлгэх, Бүх гишүүдийн хурлын баримт бичгийг хүлээн авч, хуулийн шаардлагад нийцсэн эсэхийг хянах ажлыг хоёрдугаар улиралд багтаан хийхээр төлөвлөн ажиллаж байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР